

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/179/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаангом хот

2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн "Увс Финанс аудит" ХХК

аудитор: Я.Тунгалаг

Утас: 99459698 Цахим хаяг: anu_gantun@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ЦАГААНХАЙРХАН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Д.БУРМАА ТАНАА

2023.02.20 № ЦРА-2023/179/НА-СТА-ТЦЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаанхайрхан сумын Эрүүлийн мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

ОНХС-ийн хөрөнгөөр 4,155.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, сумын давсан орлогоос Далан нуруу багийн эмчид 2,800.0 мянган төгрөгийн мотоцикль, 2,500.0 нярайн дулаацуулагч, 14,026.2 мянган төгрөгийн ширээ, сандал, шкаф зэрэг хөрөнгө үнэ төлбөргүй ирж, төсвийн хөрөнгөөр 4,000.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж худалдаж авсан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0200200314

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is cursive and extends to the right of the stamp.

М.БАТСУУРЬ

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Дүгнэлтийн үндэслэл	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4.1 Ерөнхий зүйл	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/(Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	65,821,498.09	118,113,656.57
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,927,713.11	27,939,552.69
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	5,927,713.11	27,939,552.69
3121	Төгрөг	5,927,713.11	27,939,552.69
31211	Төрийн сангийн харилцах	5,927,625.41	27,939,552.69
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	87.70	00.00
33	АВЛАГА	17,523,800.00	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	17,523,800.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	42,369,984.98	90,174,103.88
351	Түүхий эд материал	17,488,645.50	43,974,905.10
35130	Эм боох материал	17,488,645.50	43,974,905.10
354	Хангамжийн материал	24,881,339.48	46,199,198.78
35410	Бичиг хэргийн материал	1,499,300.00	1,544,300.00
35420	Аж ахуйн материал	19,008,639.47	30,929,761.47
35430	Сэлбэг хэрэгсэл	600,000.00	1,300,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	10,250,600.00
35460	Хүнсний материал	3,773,400.01	2,174,537.31
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,333,298,607.79	1,281,693,406.17
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,333,298,607.79	1,281,693,406.17
392	Биет хөрөнгө	1,316,830,607.79	1,265,225,406.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,130,335,809.00	1,130,335,809.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-18,399,673.08	-41,619,385.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	125,531,833.00	128,331,833.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-44,471,833.00	-68,615,166.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,536,869.09	45,911,897.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	-16,179,783.49	-22,025,655.29
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,539,713.00	33,565,913.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,979,633.64	-10,170,414.01
39214	Бусад үндсэн хөрөнгө	153,186,079.00	153,161,079.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-64,268,772.09	-83,650,503.74
393	Биет бус хөрөнгө	16,468,000.00	16,468,000.00
39301	Програм хангамж	440,000.00	440,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-440,000.00	-440,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,468,000.00	16,468,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,399,120,105.88	1,399,807,062.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,399,120,105.88	1,399,807,062.74
51	Засгийн газрын хувь оролцоо	1,399,120,105.88	1,399,807,062.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	234,693,025.00	234,693,025.00
51101	Өмч: - төрийн	234,693,025.00	234,693,025.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,139,873,360.24	1,140,560,317.10
51210	Өмнөх үеийн үр дүн	1,139,873,360.24	1,139,873,360.24
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	686,956.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,553,720.64	24,553,720.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,399,120,105.88	1,399,807,062.74

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,770,263,841.46	703,605,039.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,114,858,171.46	64,113,289.60
120	Нийтлэг татварын бус орлого	1,114,858,171.46	64,113,289.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,114,858,171.46	64,113,289.60
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,114,858,171.46	64,113,289.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	221,387,770.00	639,491,750.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	434,017,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	120,648,200.00	4,225,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	11,860,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,225,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	108,788,200.00	00.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,692,200.00	62,692,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,692,200.00	62,692,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	38,047,370.00	572,574,050.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	38,047,370.00	572,574,050.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	675,153,307.63	702,918,082.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	675,153,307.63	702,918,082.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	633,856,625.63	699,444,566.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	326,544,647.72	351,158,595.56
210101	Үндсэн цалин	281,339,213.92	253,973,790.15
210102	Нэмэгдэл	00.00	61,524,399.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,690,999.80	5,001,997.38
210104	Урамшуулал	35,474,434.00	26,041,128.45
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	4,617,280.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,690,694.17	43,427,666.75
210201	Тэтгэврийн даатгал	30,095,050.68	30,443,009.08
210202	Тэтгэмжийн даатгал	3,237,624.34	3,515,720.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,559,859.29	2,782,336.54
210204	Ажилгүйдлийн даатгал	527,105.56	607,872.78
210205	Эрүүл мэндийн даатгал	5,271,054.30	6,078,727.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,881,018.00	55,094,184.00
210301	Гэрэл, цахилгаан	3,555,834.00	3,625,000.00
210302	Түлш, халаалт	57,005,184.00	51,369,184.00
210303	Цэвэр, бохир ус	320,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,779,266.00	55,879,980.00
210401	Бичиг хэрэг	2,267,700.00	3,356,380.00

210402	Тээвэр, шатахуун	33,464,780.00	43,924,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,949,200.00	2,157,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,119,400.00	2,579,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,978,186.00	3,861,500.00
2105	Нормативт зардал	107,854,712.00	105,420,380.81
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	99,868,167.00	93,870,173.11
210502	Хоол, хүнс	6,856,545.00	11,550,207.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,130,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,689,500.00	3,559,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	499,500.00	1,215,000.00
210604	Урсгал засвар	1,190,000.00	2,344,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,124,000.00	2,736,000.00
210702	Дотоод албан томилолт	1,124,000.00	2,736,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	956,332.00	1,382,330.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,000.00	300,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	110,600.00	213,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	47,510.00	147,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	23,350.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	432,000.00	253,000.00
210807	Газрын төлбөр	65,872.00	164,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,336,455.74	80,786,429.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,081,400.00	1,700,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,255,055.74	79,086,429.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,296,682.00	3,473,516.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,085,500.00	2,875,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,085,500.00	2,875,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	211,182.00	598,516.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	211,182.00	598,516.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,095,110,533.83	686,956.86
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,095,110,533.83	686,956.86

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	637,881,870.00	657,015,550.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	637,881,870.00	657,015,550.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	434,017,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	120,648,200.00	4,225,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	11,860,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн	00.00	4,225,000.00

	захирагчид хуваарилсан хөрөнгө		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	108,788,200.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,692,200.00	62,692,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,692,200.00	62,692,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20,523,570.00	590,097,850.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,523,570.00	590,097,850.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	631,954,156.89	631,003,710.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	631,954,156.89	631,003,710.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	590,657,474.89	627,530,194.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	326,544,647.72	351,158,595.56
210101	Үндсэн цалин	281,339,213.92	253,973,790.15
210102	Нэмэгдэл	00.00	61,524,399.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,690,999.80	5,001,997.38
210104	Урамшуулал	35,474,434.00	26,041,128.45
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	4,617,280.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,690,694.17	43,427,666.75
210201	Тэтгэврийн даатгал	30,095,050.68	30,443,009.08
210202	Тэтгэмжийн даатгал	3,237,624.34	3,515,720.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,559,859.29	2,782,336.54
210204	Ажилгүйдлийн даатгал	527,105.56	607,872.78
210205	Эрүүл мэндийн даатгал	5,271,054.30	6,078,727.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,881,018.00	60,494,184.00
210301	Гэрэл, цахилгаан	3,555,834.00	3,625,000.00
210302	Түлш, халаалт	57,005,184.00	56,769,184.00
210303	Цэвэр, бохир ус	320,000.00	100,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,423,780.00	61,846,580.00
210401	Бичиг хэрэг	1,609,800.00	3,378,180.00
210402	Тээвэр, шатахуун	33,464,780.00	48,775,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,949,200.00	2,157,800.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	23,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200,000.00	2,565,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,100,000.00	4,946,500.00
2105	Нормативт зардал	105,042,703.00	95,395,778.11
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	92,444,658.00	84,348,753.11
210502	Хоол, хүнс	8,098,045.00	9,547,025.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,500,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,529,500.00	9,389,060.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,430,000.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	499,500.00	1,215,000.00
210604	Урсгал засвар	1,600,000.00	8,174,060.00
2107	Томилолт, зочны зардал	1,124,000.00	2,736,000.00

210702	Дотоод албан томилолт	1,124,000.00	2,736,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	956,332.00	1,382,330.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,000.00	300,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	110,600.00	213,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	47,510.00	147,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	23,350.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	432,000.00	253,000.00
210807	Газрын төлбөр	65,872.00	164,680.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,464,800.00	1,700,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,464,800.00	1,700,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,296,682.00	3,473,516.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,085,500.00	2,875,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	41,085,500.00	2,875,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	211,182.00	598,516.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	211,182.00	598,516.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,927,713.11	26,011,839.58
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	4,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	4,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	4,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	4,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-4,000,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,927,713.11	22,011,839.58
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	5,927,713.11
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,927,713.11	27,939,552.69

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/	
					Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-	234,693,025.00	24,553,720.64	1,139,873,360.24	00.00	1,399,120,105.88

	нээрх үлдэгдэл					
D01	2021 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	234,693,025.00	24,553,720.64	1,139,873,360.24	00.00	1,399,120,105.88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	234,693,025.00	24,553,720.64	1,139,873,360.24	00.00	1,399,120,105.88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	686,956.86	00.00	686,956.86
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	234,693,025.00	24,553,720.64	1,140,560,317.10	00.00	1,399,807,062.74

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	655,278,200.00	550,562,210.42	104,715,989.58	84%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	655,278,200.00	550,562,210.42	104,715,989.58	84%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	655,278,200.00	550,562,210.42	104,715,989.58	84%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	408,168,800.00	351,158,595.56	57,010,204.44	86%
210101	Үндсэн цалин	359,474,900.00	253,973,790.15	105,501,109.85	71%
210102	Нэмэгдэл	0.00	61,524,399.58	-61,524,399.58	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,453,900.00	5,001,997.38	451,902.62	92%
210104	Урамшуулал	38,200,000.00	26,041,128.45	12,158,871.55	68%
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	4,617,280.00	422,720.00	92%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,021,100.00	43,427,666.75	7,593,433.25	85%
210201	Тэтгэврийн даатгал	34,694,400.00	30,443,009.08	4,251,390.92	88%
210202	Тэтгэмжийн даатгал	4,081,700.00	3,515,720.71	565,979.29	86%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,265,300.00	2,782,336.54	482,963.46	85%
210204	Ажилгүйдлийн даатгал	816,300.00	607,872.78	208,427.22	74%
210205	Эрүүл мэндийн даатгал	8,163,400.00	6,078,727.64	2,084,672.36	74%
2104	Хангамж, бараа материалын зардал	64,463,600.00	61,371,580.00	3,092,020.00	95%
210401	Бичиг хэрэг	3,330,000.00	3,378,180.00	-48,180.00	101%

210402	Тээвэр, шатахуун	52,679,000.00	48,550,000.00	4,129,000.00	92%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,189,600.00	1,907,800.00	281,800.00	87%
210404	Ном, хэвлэл	100,000.00	23,200.00	76,800.00	23%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,039,900.00	2,565,900.00	-526,000.00	126%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,125,100.00	4,946,500.00	-821,400.00	120%
2105	Нормативт зардал	110,498,700.00	77,246,978.11	33,251,721.89	70%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	98,998,700.00	66,199,953.11	32,798,746.89	67%
210502	Хоол, хүнс	10,000,000.00	9,547,025.00	452,975.00	95%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00	0.00	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,100,000.00	11,789,060.00	310,940.00	97%
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	4,000,000.00	0.00	100%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	1,215,000.00	285,000.00	81%
210604	Урсгал засвар	6,600,000.00	6,574,060.00	25,940.00	100%
2107	Томилолт, зочны зардал	2,756,000.00	2,486,000.00	270,000.00	90%
210702	Дотоод албан томилолт	2,756,000.00	2,486,000.00	270,000.00	90%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,770,000.00	1,382,330.00	387,670.00	78%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	300,000.00	0.00	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	216,000.00	144,000.00	60%
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	213,450.00	36,550.00	85%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	168,000.00	147,200.00	20,800.00	88%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,000.00	88,000.00	7,000.00	93%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	432,000.00	253,000.00	179,000.00	59%
210807	Газрын төлбөр	165,000.00	164,680.00	320.00	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,500,000.00	1,700,000.00	2,800,000.00	38%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,500,000.00	1,700,000.00	2,800,000.00	38%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ	655,278,200.00	578,501,763.11	76,776,436.89	88%

	ҮҮСВЭР				
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	615,985,400.00	543,433,963.00	72,551,437.00	88%
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	615,985,400.00	543,433,963.00	72,551,437.00	88%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	39,292,800.00	35,067,800.11	4,224,999.89	89%
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,292,800.00	35,067,800.11	4,224,999.89	89%
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	27,939,552.69	-27,939,552.69	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	47.00	47.00	0.00	100%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.00	23.00	0.00	100%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	0.00	100%
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	0.00	100%

2.6 АУДИТ ХИЙСЭН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	62,692,700.00	62,094,184.00	598,516.00	99%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	62,692,700.00	62,094,184.00	598,516.00	99%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,692,700.00	62,094,184.00	598,516.00	99%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,092,700.00	60,494,184.00	598,516.00	99%
210301	Гэрэл, цахилгаан	3,625,000.00	3,625,000.00	0.00	100%
210302	Түлш, халаалт	57,147,700.00	56,769,184.00	378,516.00	99%
210303	Цэвэр, бохир ус	320,000.00	100,000.00	220,000.00	31%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,600,000.00	1,600,000.00	0.00	100%
210604	Урсгал засвар	1,600,000.00	1,600,000.00	0.00	100%

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	62,692,700.00	62,692,700.00	0.00	100%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	62,692,700.00	62,692,700.00	0.00	100%
320001	Орон нутгийн төсвөөс	62,692,700.00	62,692,700.00	0.00	100%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	5,927,625.41	-5,927,625.41	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төв нь үйлчлүүлэгчдэд ээлтэй, чанартай, тэгш хүртээмжтэй, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэн, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулж, өвчлөл эндэгдэлийг бууруулахад чиглэн үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн тухай хууль- 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан.
- ✓ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль- 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль -2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 686.9 мянган төгрөгөөр буюу 0.04 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,927.7	27,939.5	22,011.8
Авлага	17,523.8	0.0	-17,523.8
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	42,369.9	90,174.1	47,804.1
Үндсэн хөрөнгө	1,333,298.6	1,281,693.4	-51,605.2
Нийт хөрөнгө	1,399,120.1	1,399,807.0	686.9
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,399,120.1	1,399,807.0	686.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,399,120.1	1,399,807.0	686.9

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь өмнөх оны үзүүлэлтээс 22,011.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлага 17,523.8 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 90,174.1 мянган төгрөг болж 47,804.1 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар ирсэн бараа материалаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,281,693.4 мянган төгрөг болж 51,605.2 мянган төгрөгөөр буурсан нь шинээр 27,481.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн ч, 4,305.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө хасагдаж, хөрөнгийн элэгдлийн зардал өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,399,807.0 мянган төгрөг болж 686.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 757,724.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 101,306.9 мянган төгрөгөөр бууруулж 656,417.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 656,417.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 62,094.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 594,322.8 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 62,094.1 мянга Эрүүл мэндийн даатгалын сангаас 594,322.8 мянга нийт 656,417.0 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаанд 628,477.4 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 598.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
	Улсын төсвөөс	594,322.8	566,383.2	27,939.5	95.2%
	Орон нутгийн төсвөөс	62,094.1	61,495.6	598.5	99%

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал нь албан хаагчид өвчтэй, цалингүй чөлөөтэй байсан зэргээс шалтгаалан 1,803.5 мянга, тээвэр шатахуун 3,904.0 мянга, шуудан холбоо 31.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 387.6 мянга, ном хэвлэл, хангамж, бараа материалын зардал 1,282.3 мянга, дотоод албан томилолт 20.0 мянга, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл 17,399.2 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 2,800.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжсэнтэй холбоотой байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян жанжин хишиг аудит ХХК-ийн аудитор А.Дугармаа гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян жанжин хишиг аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 702.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 7.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 702.3 сая төгрөгийн 1 хувиар буюу 7.0 сая төгрөгөөр 80 хувиар тооцож 5.6 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хамаарах зүйл заалтын хүрээнд зөрчил гараагүй байна. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төв нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнө оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цагаанхайрхан сумын Эрүүл мэндийн төвийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ


ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ
ХХК-ийн АУДИТОР



М.БАТСУУРЬ/
М.БАТ-АМГАЛАН/
А.ДУГАРМАА/

2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр